

НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРЭГ  
Тогтоол шийдвэрийн биелэлт

2021.03.25

Багахангай дүүрэг

№	Эрх зүйн Актын нэр он, сар, дугаар	Зүйл, заалтын дугаар, агуулга	Хяналтанд байгаа заалтыг хэрэгжүүлэх талаар төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжилт	Үр нөлөө, үр дүн	Хэрэгжилтийн хувь	Үнэлгээ
Нийслэлийн Засаг даргын захирамж							
1.	Гамшгаас хамгаалах дадлага, сургууль, бэлэн байдлын үзлэг зохион байгуулах тухай” 2021-02-05 А/59	1.Болзошгүй гамшгийн аюулаас хүн ам, хүрээлэн байгаа орчныг хамгаалах, урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд аж ахуй нэгж байгууллага, иргэдийг сургах, харилцан ажиллагааг сайжруулах зорилгоор нийслэлийн хэмжээнд 2021 онд зохион байгуулах гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль, бэлэн байдлын үзлэг, удирдах бүрэлдэхүүний сургалтын хуваарийг хавсралтаар баталсугай. 2.Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль, Нийслэлийн Засаг даргын нэрэмжит гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг, удирдах бүрэлдэхүүний сургалтад гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн оролцоог хангаж, шаардлагатай хөрөнгийг цаг хугацаанд нь шийдвэрлэж, сургалт, дадлага сургуулийг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг нийслэлийн Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн дарга,	Захирамжийн хавсралтаар батлагдсан хуваарийн дагуу 2021 оны 3 дугаар сард Удирдах бүрэлдэхүүний сургалтыг Онцгой комиссын гишүүдийг хамруулан зохион байгуулах	2021 оны 03 дугаар сард гамшгаас хамгаалах ангиллын сургалт зохион байгуулах ажлын удирдамжийн дагуу гамшгаас хамгаалах сургалтыг Онцгой байдлын хэлтсийн орлогч, Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, ахлах байцаагч дэд хурандаа, Гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахмад, Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн нарыг оролцуулан удирдах ажилтны дунд 1, ААНБ-д 2 нийт 3 удаа зохион байгуулж, 55 ажилтан, алба хаагчид хамрагдсан байна.	Хуваарийн дагуу хугацаанд нь зохион байгуулсан.	100	

		дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.					
2.	Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, авто зам ашигласны төлбөр хураах талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-02-09 А/75	3.1.Албан татвар, төлбөр хураах ажлыг нутаг дэвсгэрийн зарчмаар зохион байгуулж, тухайн нутаг дэвсгэрт автотээврийн хэрэгсэл эзэмшиж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг татварт бүрэн хамруулж, татварт хамрагдалтын түвшинг өмнөх жилээс нэмэгдүүлэх;	2021 оны төсвийн орлогын төлөвлөгөөний сар, улирлын хуваарийн дагуу биелүүлэх татварт хамрагдалтыг сайжруулах	Автотээврийн хэрэгсэл эзэмшиж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг татварт бүрэн хамруулж, татварт хамрагдалтын түвшинг өмнөх оноос нэмэгдүүлэх талаар ажиллаж, 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар 8,174.0 сая төгрөгийн татвар төвлөрүүлэн ажиллаж байна.	татварт хамрагдалтын түвшинг өмнөх жилээс нэмэгдүүлсэн байна.	50	
		3.2.Албан татвар, төлбөр хураах ажлыг Засаг даргын дэргэдэх хэлтэс болон харьяа байгууллагатай хамтран /Тээврийн цагдаагийн алба, Замын цагдаагийн хэлтэс, хороод, Автотээврийн үндэсний төвийн салбар, банкны байгууллага түүнчлэн холбогдох бусад байгууллага/ Татварын хэлтэс зохион байгуулж ажиллах;	Дүүрэгт бүртгэлтэй тээврийн хэрэгслийг татвар бүрэн хамруулсан байх	Татварын хэлтэс нь Нийслэлийн Засаг даргын 2021.02.09-ний өдрийн А/75, дүүргийн Засаг даргын 2021.02.25-ны өдрийн А/21, Татварын ерөнхий газрын даргын 2021.02.18-ны өдрийн А/21 дүгээр тушаалын дагуу ажлын хэсэг байгуулан дүүргийн 1, 2-р хороо болон цагдаагийн хэлтэстэй хамтран авто тээврийн хэрэгслийн оношилгоог 04 дүгээр сарын 08-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөөд байна.	АТБӨЯХАТ-ын төлбөр хураамж болон хасагдах тээврийн хэрэгсэлийг татварт бүрэн хамрагдуулна.	50	
		3.3.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын албан татвар, төлбөрийг хуулийн хугацаанд Нийслэлийн замын сангийн дансанд төвлөрүүлэх, Нийслэлийн 2021 оны төсвийн орлогын төлөвлөгөөний сар, улирлын хуваарийг мөрдөж ажиллах	2021 оны төсвийн орлогын төлөвлөгөөний сар, улирлын хуваарийн дагуу биелүүлэх татварт хамрагдалтыг сайжруулах	2021 оны төсвийн орлогын төлөвлөгөөний сар, улирлын хуваарийн дагуу АТБӨЯХАТ-т 2021 оны 03 дугаар сарын 17-ны байдлаар төлөвлөгөө 6,416.7 мянган төгрөг төвлөрүүлэхээс 3,211.0 мянган төгрөг төвлөрүүлж биелэлт 50.0 хувьтай ажиллаж байна.	АТБӨЯХАТ-ын төлбөр хураамж болон хасагдах тээврийн хэрэгслийг татварт бүрэн хамрагдуулна.	50	
		3.4.Албан татвар, төлбөр хураахтай холбогдсон мэдээлэл, тээврийн хэрэгслийн нэгдсэн цахим үйлчилгээ "smartcar.mn", татварын удирдлагын нэгдсэн "е-	Дүүрэгт бүртгэлтэй тээврийн хэрэгслийг татвар бүрэн	3.4. АТБӨЯХАТ-ын төлбөрийг тээврийн хэрэгслийн нэгдсэн цахим үйлчилгээ "smartcar.mn", татварын удирдлагын нэгдсэн "e-tax.mta.mn, e-tax.mta.mn"	АТБӨЯХАТ-ын төлбөр хураамжийн цахимаар төлүүлж хэвшсэн байна	80	

		tax.mta.mn, i-tax.mta.mn” систем, “и-баримт” гар утасны аппликэйшн, “гэрэгэ” киоск төхөөрөмж ашиглан албан татвар, төлбөрөө төлөх талаар заавар, сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд түгээх, сурталчлах	хамруулсан байх	систем, “е-баримт” гар утасны аппликэйшн, “гэрэгэ” киоск төхөөрөмж ашиглан албан татвар, төлбөрөө төлөх талаар заавар, сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр хороод болон цагдаагийн хэлтэстэй хамтран татвар төлөгч нарт мэдээлэл өгч ажиллаж байна.			
3.	Сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтыг нэмэгдүүлэх тухай 2021-01-19 А/17	2.Хавсралтад заасан хуваарийн дагуу хүүхдүүдийг үргэлжлүүлэн суралцуулахыг холбогдох төрийн бус өмчийн цэцэрлэгийн эрхлэгч нарт, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Нийслэлийн Боловсролын газар /Ж.Гантулга/-т, сургалтын орчны эрүүл ахуй, аюулгүй байдалд хяналт тавьж ажиллахыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар /Л.Эрдэнэчулуун/-т, нэмэлт элсэлтээр хамрагдаж буй 4730 хүүхдийн хоолны зардлыг зохих журмын дагуу тооцож олгохыг дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Хуваарийн дагуу хүүхдүүдийг үргэлжлүүлэн суралцуулах, өхоолны зардлыг зохих журмын дагуу тооцож олгох	Сургуулийн өмнөх боловсролын хамрагдалт дүүргийн хэмжээнд 100% байсан ба хоолны мөнгийг зохих журмын дагуу зарцуулсан байна. 2020 оны 11 дүгээр сараас эхлэн улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбоотойгоор танхимын хичээл хичээллээгүй болно. СӨБ-ын хамран сургалтыг нэмэгдүүлэх зорилгоор 2020-2021 оны хичээлийн жилд төрийн бус өмчийн цэцэрлэгүүдийн сул оронд нэмэлт элсэлтээр цэцэрлэгт хамран суралцуулсан хүүхэд байхгүй байна.	Дүүргийн хэмжээнд СӨБ-д хамрагдалт 100% байна.	90	
4.	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай	1.“Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г нэгдүгээр, “Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”-г хоёрдугаар хавсралтаар баталсугай. 4.Төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, биелэлт, хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар хууль, журмын	Дүүрэгт хамааралтай заалтыг хэрэгжүүлэх	Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнөөс 31 зорилтын 64 заалтыг хяналтад авч, хэрэгжилтийг ханган ажиллав.	Төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллав.	30	

	2021-02-26 A/115	дагуу тайлагнан ажиллах					
5.	Ажлын хэсэг байгуулах тухай 2021-02-10 A/85	2.Нутаг дэвсгэртээ түр цэг болон явуулын шинжилгээний баг ажиллуулж, өрх бүрийн нэг иргэнийг шинжилгээнд хамруулахад харьяа хэлтэс, албадын албан хаагчдыг оролцуулан зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай	Өрх бүрийн нэг иргэнийг шинжилгээнд хамруулах	Багахангай дүүргийн 2-р хорооны нутаг дэвсгэрт Коронавирусын өвчлөл бүртгэгдсэнтэй холбогдуулан дүүргийн Онцгой комиссын даргын шийдвэрийн дагуу 2-р хороонд шинжилгээний түр цэгийг тохижуулж, 2021 оны 03-р сарын 17-ны өдрийн 10.00 цагаас 19.30 цаг хүртэл 18-аас дээш насны 577 иргэн PCR шинжилгээнд хамруулахаас 546 иргэнийг хамрууллаа. Шинжилгээний хамрагдалт 94,6%-тай хэрэгжсэн. 03-р сарын 17-ны 22.00 цагт сорьцыг ХӨСҮТ-ийн Вируслогийн лабораторид хүргэв. Шинжилгээний хариу бүгд СӨРӨГ гарсан байна.	Өрх шинжилгээнд хамрагдав.	бүр	10
		3.Дээрх арга хэмжээг хугацаанд нь зохион байгуулахад нутгийн захиргааны болон харьяа байгууллагуудын албан хаагчдыг нэгдсэн зохион байгуулалтаар ажиллуулахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /Т.Оюунчимэг/-т, албан хаагчдыг бүрэн хамруулахыг байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.	Нутгийн захиргааны болон харьяа байгууллагуудын албан хаагчдыг нэгдсэн зохион байгуулалтаар ажиллуулах	Дүүргийн хэмжээнд “Нэг хаалга-Нэг шинжилгээ” авах ажлыг зохион байгуулахад Онцгой байдлын хэлтсээс-6, Цагдаагийн хэлтсээс-2, Мэргэжлийн хяналтын тасгаас-1, Эрүүл мэндийн төвөөс-10, Хороодоос-16, Засаг даргын Тамгын газраас-6, Багахангайн үйлдвэр технологийн паркаас-8 нийт 49 алба хаагч, 6 техник хэрэгсэлтэйгээр ажилласан байна. 2021 оны 3 дугаар сарын 16-ны өдөр дүүргийн 2-р хороонд	Нутгийн захиргааны болон харьяа байгууллагуудын 49 албан хаагч ажиллав.		

				коронавирусын 2 тохиолдол батлагдсантай холбоотойгоор халдварын голомтод шинжилгээ, тандалт судалгаа, ариутгал халдваргүйтгэл хийх, хязгаарлалтын дэглэм тогтоох ажилд ОБХ, ЦХ, ЭМТ, МХТ-ын 28 ажилтан албан хаагч ажилласан байна.			
6.	Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2021-02-10 А/87	1.Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжсэн хугацаанд Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 14 дүгээр тушаалаар баталсан иргэдийн эмнэлгийн тусламж үйлчилгээ авах, хүнс, ус, түлш, эм, эмнэлгийн хэрэгслийн худалдаа эрхлэх байгууллагаар үйлчлүүлэх, зорчих хөдөлгөөнийг зохицуулах түр журмын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг нийслэлийн Онцгой байдлын газар (А.Дашням), нийслэлийн Цагдаагийн удирдах газар (Ш.Цогбаатар), нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар (Л.Эрдэнэчулуун), дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Дүүргийн 1, 2 дугаар хорооны баталгаат бус болон орон нутгийн чанартай авто замд хөдөлгөөнд болон хяналтын пост ажиллуулах -Иргэдийн зорчих хөдөлгөөнийг хянах qr код уншуулж буйд хяналт тавих	Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 2021 оны 02 дугаар сарын 11-23-ны өдөр хүртэл хяналтын цэг, гудамж талбайд эргүүл хяналт шалгалтаар Онцгой байдлын хэлтсээс 10, Цагдаагийн хэлтсээс 10, төрийн албан хаагчдаас 88 албан хаагч үүрэг гүйцэтгэсэн байна. Мөн энэ хугацаанд эмнэлгийн эм, хэрэгсэл татан авалтыг хийгээгүй байна.	Худалдаа үйлчилгээний байгууллагуудаар үйлчлүүлж буй иргэдийн зорчих хөдөлгөөний хянах QR код уншуулж буй эсэхэд хяналт тавин ажиллаж 23 үйлчилгээний газарт давхардсан тоогоор 6900 иргэн QR код уншуулж 7200 иргэн гараар бүртгэл хөтлөн 14100 иргэний биеийн халууны хэмжин бүртгэлжүүлсэн байна.	100	
		3.Хязгаарлалт тогтоогоогүй төрийн байгууллага, хуулийн этгээдийн ажилтан, албан хаагчдын 10-15 хувийг ажлын газрын үнэмлэх, албан байгууллагын тодорхойлолтыг үндэслэн хувийн болон албаны тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцох нөхцөл боломжийг бүрдүүлж, хяналт тавьж	Дүүргийн 1, 2 дугаар хорооны баталгаат бус болон орон нутгийн чанартай авто замд	2021.02.23-наас 2021.03.19-ний өдөр хүртэлх хугацаанд Аривжих төвийн уулзвар, Үнэгтэй гэр хороолол, Багахангай дүүргийн үйлдвэрийн бүс, алсын худаг, төмөр замын гарам хөдөлгөөнт 5 цэг, байнгын хяналтын пост 1 цэг, явган эргүүлийн 2 чиглэл нийт 8 цэгт холбогдох	Энэ хугацаанд давхардсан тоогоор нийт 158 ажилтан албан хаагчийн ажлын газрын үнэмлэх, албан байгууллагын тодорхойлолтыг үндэслэн		

	ажиллахыг Тээврийн Цагдаагийн албаны Замын Цагдаагийн газар (С.Жавхланбаатар), нийслэлийн Цагдаагийн удирдах газар (Ш.Цогбаатар), дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	хөдөлгөөнд болон хяналтын пост ажиллуулах	мэргэжлийн байгууллагуудаас өдөрт 11 алба хаагч, 7 машинтайгаар 24 цагаар үүрэг гүйцэтгэн ажилласан.	хөдөлгөөнд оролцуулсан.		
	5.Улаанбаатар хотын авто тээврийн шалган нэвтрэх товчоодын хөдөлгөөнд зохицуулалт хийж, хязгаарлалт тогтоогоогүй төрийн байгууллага, хуулийн этгээдийн үйлчилгээ эрхлэгч, жолооч, зорчигчдын PCR шинжилгээний хариуг үндэслэн, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлж нэвтрүүлэх, маршрутын бус замын хяналтыг чангатгаж ажиллахыг нийслэлийн Эрүүл мэндийн газар (Б.Бямбадорж), нийслэлийн Онцгой байдлын газар (А.Дашням), нийслэлийн Цагдаагийн удирдах газар (Ш.Цогбаатар), нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар (Л.Эрдэнэчулуун), Тээврийн Цагдаагийн албаны Замын Цагдаагийн газар (С.Жавхланбаатар), нийслэлийн Мал эмнэлгийн газар (А.Нарантуяа), дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Дүүргийн 1, 2 дугаар хорооны баталгаат бус болон орон нутгийн чанартай авто замд хөдөлгөөнд болон хяналтын пост ажиллуулах	Авто тээврийн шалган нэвтрүүлэх хяналтын товчоогоор УБ хотруу орсон машин 1912, зорчигч 3294, гарсан машин 1930 зорчигч 4062 ба нийт 3842 машины 7356 зорчигчийг бүртгэж эрүүл мэндийн асуумжийг авч ажилласан ба сэжигтэй тохиолдол бүртгэгдээгүй. Буцаасан 22 автомашин, 54 зорчигч бүртгэгдсэн байна. Дүүргийн шуурхай штабаас гаргасан шийдвэрийн дагуу Эрүүл мэндийн төв нь Улаанбаатар хотоос ирэх иргэдийг замын хяналтын постон дээр бүртгэн PCR болон түргэвчилсэн шинжилгээг авч хяналт тавин ажиллаж байна.	Хөдөлгөөнт эргүүл шалгалтын 5, хяналтын пост 1 ажиллалаа. Мөн Гаднаас орж ирэх иргэдийг тухай бүр шинжилгээнд хамруулж байна	100	
	6.Халдвар хамгаалал, хорио цээр, хязгаарлалтын дэглэмийг баримтлан, үйл ажиллагаагаа тасралтгүй, хэвийн явуулах	Халдвар хамгаалал, хорио цээр, хязгаарлалтын	Коронавируст халдвар /КОВИД-19/-аас урьдчилан сэргийлэх үүднээс нийт 35 аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаандаа	Халдвар хамгааллын дэглэмийг баримтлан ажиллаж	100	

		нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдлагуудад зөвлөсүгэй.	дэглэмийг баримтлан, үйл ажиллагаагаа тасралтгүй, хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлж ажиллах	халдвар хамгааллын дэглэм сахиулах, ажил үйлчилгээгээ хэвийн явуулж байна.	байна.		
7.	Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд худалдаа, үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-02-10 А/86	1.Коронавируст /Ковид-19/ халдварт өвчинтэй тэмцэх, халдварын эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээ авах зорилгоор бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд хүнсний томоохон зах, худалдааны төвүүдийн ажиллах цагийн хуваарийг хавсралтаар баталсугай. 3.Энэхүү захирамжийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба /Т.Гантөмөр/-нд, хяналт тавьж ажиллахыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар /Л.Эрдэнэчулуун/, нийслэлийн Цагдаагийн удирдах газар /Ш.Цогбаатар/, дүүргийн Засаг дарга нарт тус тус даалгасугай	-	Дүүрэгт томоохон зах худалдааны төв үйл ажиллагаа явуулдаггүй бөгөөд хүнсний дэлгүүрүүд цагийн хуваарийн дагуу 09.00-22.00 цагийн хооронд ажиллав.	-	-	
8.	Журам шинэчлэн батлах тухай 2021-02-02 А/52	1.“Захирамжлалын баримт бичиг гаргах ажиллагааны журам”-ыг шинэчлэн 1 дүгээр, “Хяналтын дагалдах хуудасны загвар”-ыг 2 дугаар, “Төсөлд ирүүлсэн саналын товъёгийн загвар”-ыг 3 дугаар хавсралтаар баталсугай. 3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /Т.Оюунчимэг/-т үүрэг болгосугай. Журамтай танилцах	“Захирамжлалын баримт бичиг гаргах ажиллагааны журам”-ыг шинэчлэн гаргах	“Захирамжлалын баримт бичиг гаргах ажиллагааны журам”-ын төслийг шинэчлэн боловсруулж, удирдлагуудад танилцууллаа. Уг төсөлд “Хяналтын дагалдах хуудасны загвар”, “Төсөлд ирүүлсэн саналын товъёгийн загвар”-ыг тус тус оруулаад байна.	Журмын төслийг боловсруулан, удирдлагуудад танилцуулаад байна.	50	

9.	Шар усны үерээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай 2021-01-25 А/27	1.3.Үерийн хамгаалалтын барилга байгууламж, хөрсний болон булгийн ус урсах жалга, сувагчлалын трасс, хамгаалалтын зурваст суурьшсан айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудын газрын нөхөн олговрын тооцоо судалгааг нарийвчлан гаргаж танилцуулах, газар чөлөөлөх ажлыг зохион байгуулж ажиллахыг дүүргүүдийн Засаг дарга нарт	Дүүргийн Онцгой комиссын албан даалгавар төлөвлөх, хэрэгжүүлэх	Дүүрэгт үерийн хамгаалалтын барилга байгууламж, үерийн ус урсах жалга, сувагчлалын трасс, хамгаалалтын сувагт одоогийн байдлаар суурьшсан айл өрх, ААНБ байхгүй.	Шар усны үерт өртсөн айл өрх байхгүй байна.	100	
		1.4.Хамгаалалтын бүсэд орсон барилга байгууламжийн үзлэг шалгалтыг 2021 оны 04 дүгээр сарын 01-ний дотор хийж, хур хогийг цэвэрлэн усны урсах нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг Геодези, Усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ /Л.Ариунтуяа/, дүүргийн Засаг дарга нарт	Халиа, тошин, шар усны үерийн аюулаас урьчилан сэргийлэх, далан сувгийн цэвэрлэгээ үйлчилгээг зохион байгуулах	Багахангай тохижилт ОНӨААТҮГ нь 1, 2 дугаар хороо холбосон 400 м үерийн сувгийн хог хаягдлыг цэвэрлэж 1,1 тн хог хаягдлыг татан авч үерийн ус нэвтрэх нөхцөл бололцоог ханган ажиллав.	Үерийн хамгаалалтын ус зайлуулах сувагт үзлэг шалгалтыг 7 хоногт 2 удаа тогтмол хийж нийт 12 зам талбайн үйлчилэгч хогийн цэвэрлэгээг хийв.	100	100
		1.5.Үерийн хамгаалалтын болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлын зураг төсөв боловсруулах, гамшиг ослын үед ашиглагдах машин механизм, техник тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, парк шинэчлэлт хийхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /Т.Оюунчимэг/, Геодези, Усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ /Л.Ариунтуяа/, дүүргүүдийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Гамшиг ослын үед ашиглагдах машин механзм, техник тоног төхөөрөмж байнгын бэлэн байдлыг хангах	Багахангай тохижилт ОНӨААТҮГ нь Кама ачааны машин УБА 91-47, Исузу ачааны УБЯ 45-49, УНП 16-11, ВОВСАТ олон үйлдэлт трактор, ковш 1 ширхэг, экскаватор 1 ширхэг, автовик УБУ 82-06 машин механизмыг автотээврийн үзлэг шалгалтад 1 удаа оруулав.	Гамшиг ослын үед ашиглагдах машин механизм бүрэн байдлыг хангаж осол аваараас урьдчилан сэргийлнэ.	100	100



10.	Тээврийн хэрэгсэл балансаас балансад шилжүүлэх тухай 2021-02-10 А/80	2.Тээврийн хэрэгслийг зохих журмын дагуу бүртгэн авч, өмчийн ашиглалт, хамгаалалтыг хариуцан ажиллахыг Багахангай дүүргийн Онцгой байдлын хэлтэс (Б.Цогбадрах)-т, Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтэс (А.Алтансүх)-т, Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтэс (Д.Бэхбаяр)-т, Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтэс (Г.Баатар)-т үүрэг болгосугай	Онцгой байдлын хэлтсийн даргын тушаал гарган хэрэгжүүлэх	Онцгой байдлын хэлтсийн даргын 2021 оны “Тээврийн хэрэгсэл бүртгэн авах тухай” А/12 дугаар тушаалаар Хьюндай каунти маркийн жижиг оврын автобусыг данс бүртгэлд авсан байна.	2021.03.12 ны А/07 дугаар тушаалаар авч НӨАУГ-т 2021.03.17-ны 13/5/83 тоот албан бичгээр хөрөнгө бүртгэсэн тухай мэдэгдсэн	100	
11.	Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2021-02-22 А/108	1.2.Халдварын тохиолдол бүртгэгдсэн, халдвар тархах эрсдэлтэй нутаг дэвсгэрт иргэдийн хөдөлгөөн, хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, хязгаарыг тогтоож, шаардлагатай тохиолдолд хорио цээр, хязгаарлалтын дэглэмд шилжүүлж, халдвар хамгааллыг мөрдүүлж ажиллах.  2.“Коронавируст халдвар (Ковид-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам”-ын хэрэгжилтийн бэлтгэл ажил, зохион байгуулалтыг хангаж, салбарын болон нутаг дэвсгэрийн түвшинд хэрэгжүүлэхийг нутгийн захиргааны байгууллагуудын удирдлагад, бүх шатны Засагдарга нарт үүрэг болгосугай	Хариу арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх  Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчинд сургалт сурталчилгааг зохион байгуулах	Дүүргийн Засаг даргын А/31 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дүүргийн шуурхай штаб 1 удаа хуралдаж 2 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн. Уг хурлаар нийтийн тээврийн үйлчилгээг зохион байгуулах, PCR шинжилгээ хэрхэн авах талаар аж ахуй нэгж, байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг чиглэл өгсөн.  УОК-ын даргын баталсан “Түр журам батлах тухай” 18 дугаар тушаал, “Түр журам батлах тухай” 20 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор дүүргийн Засаг даргын орлогч, дэд бүтэц, байгаль экологийн төсөл хөтөлбөрүүдийн удирдагчаар ахлуулсан ажлын хэсэг 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдөр 23 аж ахуй нэгж,	Дүүргийн хэвлэл мэдээллийн сайт, Онцгой байдлын хэлтсийн вэйб хуудсаар иргэдэд мэдээ мэдээллийг хүргүүлж, хяналтын постоор нэвтрэх иргэдийн хөдөлгөөнд зохих журмын дагуу заавар зөвлөмжийг өгч, хяналт тавин ажиллаж байна.  Онцгой байдлын хэлтсийн 2021.03.01-ний өдрийн 13/5/70 тоот албан бичгээр ААНБ-дад хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллах талаар үүрэг чиглэл өгч хяналт тавин ажиллаж байна.	100  90	

				байгууллага, худалдаа үйлчилгээ, хоол үйлдвэрлэлийн газруудаар хяналт шалгалт хийж, QR кодыг тогтмол ашиглах талаар заавар зөвлөгөө өгч ажилласан.			
		3.“Коронавируст халдвар (Ковид-19)-ын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”, “Коронавируст халдвар (Ковид-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам”-ыг иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөх талаар мэдээлж, сурталчлахыг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтэс (Г.Хонгорзул), дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, хэрэгжилтийг хангуулах.	Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан журмын хэрэгжилтийн хүрээнд Онцгой байдлын хэлтсийн веб сайтад 10 удаа байршуулж, дүүргийн Хэвлэл мэдээллийн цахим сайт, Нийслэлийн Онцгой байдлын газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтэс, 1, 2 дугаар хороо, Багахангай Төхижилт, Ус суваг ашиглалтын товчоо зэрэг байгууллага аж ахуйн нэгжийн фейсбүүк групп, пейж хуудсанд шейрлэж цахим сүлжээгээр дамжуулан олон нийтэд хүргэсэн.	Дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ, иргэд, хуулийн этгээд, олон нийтэд байгууллагын болон дүүргийн хэвлэл мэдээллийн нэгдсэн сайт, цахим орчинд байршуулсан.	100	
12.	Төсвийн хуваарь батлах тухай 2021-01-15 А/10	1.“Нийслэлийн хотын шуудын 2021 оны төсвийн орлогын сарын хуваарь”-ийг нэгдүгээр, “Нийслэлийн хотын шуудын 2021 оны төсвийн зарлага, санхүүжилтийн сарын хуваарь”-ийг хоёрдугаар, “Нийслэлийн 2021 оны төсвийн төсөв хоорондын харилцааны сарын хуваарь”-ийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.	Төсвийг хуваарийн дагуу зарцуулах	Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Төсвийн хуваарь батлах тухай” А/10 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Дүүргийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 14-ний А/09 тогтоолоор 2021 онд дүүргийн төсвийн нийт орлого, зарлагыг 6,537.0 сая төгрөгөөр, Үүнд: Нийслэлээс авах санхүүгийн дэмжлэгийг 4,238.7 сая, орон нутгийн төсвийн татварын орлого 409.6 сая, төсвийн байгууллагын өөрийн орлого 14.7 сая, ТЗШ-ийн санхүүжилт 1,519.8 сая, 2019 оны үлдэгдлээс 182.2 сая, Орон нутгийн хөгжлийн санхүүжилт	Төсвийн орлогыг нэр төрлөөр бүрдүүлж орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 93.8 сая төгрөг, гүйцэтгэлээр 160.5 сая төгрөг төвлөрүүлж биелэлт 171.1 хувьтай байна.	100	

				172.0 сая төгрөгөөр бүрдүүлэхээр, Дүүргийн урсгал зарлагыг 4,681.4 сая, Тусгай шилжүүлгийн урсгал зарлагыг 1,521.4 сая, Хөрөнгө оруулалтын зардлыг 334.1 сая төгрөг байхаар тус тус батлуулсан. Дүүргийн төсвийн орлого, зарлагын сар, улирлын хуваарийг дүүргийн Засаг даргын 2021.01.21-ний А/07 дугаар захирамжаар батлууллаа.			
13.	Коронавируст халдвар/Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2021-03-14 А/161	1.1 .Худалдаа, үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг 07:00-22:00 цаг хүртэл хугацаагаар тогтоож, зах худалдааны төвүүдийн халдвар хамгааллыг сайжруулах, ажиллах өдөр, цагийн хуваарьт зохицуулалт хийж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;	Худалдаа үйлчилгээний байгууллагад хяналт тавих	НОК-ын даргын 09 дугаар тушаал, НЗД-ын А/161 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Мэргэжлийн хяналтын байгууллагын ХАБХААХХ-ийн улсын /ахлах/ байцаагч нар 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 17-22 цагийн хооронд Багахангай дүүргийн хэмжээнд худалдаа, үйлчилгээний газруудад үйл ажиллагаанд Коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийн мөрдөлтийн байдалд хяналт шалгалт хийж ажилласан. Хяналт шалгалтын ажил үргэлжилж байна.	Шалгалтад хүнсний дэлгүүр-13, бусад-3 зэрэг нийт 16 аж ахуйн нэгж, иргэн хамрагдсан. Шалгалтаар 23 зөрчил илэрч 16 буюу 69.5 хувийг газар дээр нь арилгуулсан.		
		1.2.Халдварын тохиолдол бүртгэгдсэн, халдвар тархах эрсдэлтэй нутаг дэвсгэрт иргэдийн хөдөлгөөн, хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, хязгаарыг тогтоож, шаардлагатай тохиолдолд хорио цээр, хязгаарлалтын дэглэмд шилжүүлж,	Дүүргийн Засаг даргын 2021 оны “Хязгаарлалтын н дэглэм тогтоох тухай” 37 дугаар	2021.03.16-ны өдөр Багахангай дүүргийн 2 дугаар хорооны 5 дугаар байрны оршин суугч Н,Т нарын PCR шинжилгээний хариу эерэг гарсан тул дүүргийн Засаг даргын 2021 оны 37 дугаар	2 иргэний ойрын хавьтал болох 19 өрхийн 20 иргэнийг 14 хоног гэрийн тусгаарлалтад оруулж,	100%	

	халдвар хамгааллыг мөрдүүлж ажиллах	захирамжийг хэрэгжүүлэн ажиллах	захирамжаар тус хороонд 72 цагийн хязгаарлалтын дэглэм тогтоон ажилласан.	тус хорооны 18-аас дээш насны 546 иргэнээс ПГУ-ийн шинжилгээг 2 удаа авсан бөгөөд дээрхи иргэдийн хариу бүгд /-/ сөрөг гарсан.		
	1.3.Улаанбаатар хот доторх хүн, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 23:00-06:00 цагийн хооронд (эмнэлгийн тусламж үйлчилгээ, буяны үйлчилгээ, шөнийн нислэг, инженерийн байгууламж хот нийтийн аж ахуйн ажил, тусгай зориулалтын техник хэрэгслээс бусад) бүрэн хязгаарлаж хэрэгжилтийг хангах;	Дүүргийн Засаг даргын А/36 дугаар захирамжийн хүрээнд дүүргийн 1, 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт хяналт тавих	2021.03.14-өдрийн 06.00 цагаас 2021.03.28-ны өдрийн 06.00 цаг хүртэл хугацаанд ОБХ, ЦХ-ээс нийт 4 алба хаагч 2 тээврийн хэрэгсэлтэйгээр дүүргийн 1, 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт хяналт тавин ажиллаж байна.	Энэ хугацаанд зөрчил дутагдал гараагүй байна.	90	
	1.4.Нийслэлийн авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоодын хөдөлгөөнд зохицуулалт хийж, Багахангай, Багануур, Налайх дүүрэг болон Сонгинохайрхан дүүргийн 21, 32 дугаар хороо, Хан-Уул дүүргийн 12, 13, 14 дүгээр хорооны иргэд иргэний үнэмлэхийн хаягаар, үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан, албан хаагчид ажлын газрын үнэмлэх, байгууллагын гэрчилгээ, нотлох баримтыг үндэслэн асуумжаар нэвтрүүлэх	Дүүргийн Засаг даргын 2021 оны А/31 дүгээр захирамжаар замын цагдаагийн хяналтын цэгт ОБХ, ЦХ, ЭМТ-өөс нийт 3 алба хаагч 24 цагаар хяналт тавин ажиллаж байна.	Замын цагдаагийн хяналтын цэгээр Багахангай дүүрэгт нийт 430 тээврийн хэрэгсэл орж гарсан ба 914 иргэнийг асуумжаар нэвтрэн өнгөрүүлсэн байна.	Хяналт шалгалтын явцад коронавируст өвчний шинж тэмдэг илрээгүй байн	100%	
	1.5. Хөдөө орон нутаг руу хүндэтгэн үзэх шалтгаантай (эрүүл мэнд, албан томилолт, буяны ажил) иргэд, зайлшгүй шаардлагатай ачаа тээвэр (хүнс,	Дүүргийн Засаг даргын 2021 оны А/36 дугаар	Энэ хугацаанд УБ хот болон хөдөө орон нутаг руу ПГУ шинжилгээний 72 цагийн хариуг үндэслэн 82 иргэнийг	Энэ хугацаанд коронавируст өвчний шинж тэмдэг илрээгүй	100%	

	<p>шатахуун, өвс, тэжээл, эм эмнэлгийн хэрэгсэл, уул уурхай бусад) тээвэрлэгчдийг тухайн аймгийн Онцгой комиссын шийдвэр, ПГУ шинжилгээний 72 цагийн хүчинтэй хариуг үндэслэн гаргах, халдварын тархалт бүртгэгдсэн газраас ПГУ шинжилгээний хариутай, бусад бүс нутгаас асуумжаар халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлж оруулах, маршрутын бус замын хөдөлгөөнийг бүрэн хяналтад авах</p>	<p>захирамжыг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>	<p>тус дүүргээс гаргасан байна.Үүнд: Эрүүл мэнд-39, Буяны ажил-11, Албан томилолт-18, өвс тэжээл-3, хүнс тээвэр-14 иргэд хөдөлгөөн хийсэн байна.</p>	<p>байна.</p>		
	<p>2.Коронавируст халдвар /Ковид-19/-ын эсрэг дархлаажуулалтад иргэдийг хамруулах хуваарь төлөвлөгөөг нарийвчлан гаргах, сайн дурын ажилтны оролцоог ханган цэгийн тоог нэмэгдүүлж, иргэд, олон нийтэд мэдээлж үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг нийслэлийн Эрүүл мэндийн газар (Б.Бямбадорж), нийслэлийн Онцгой байдлын газар (А.Дашням), Цагдаагийн ерөнхий газрын дэд бөгөөд Нийслэлийн Цагдаагийн удирдах газар (Р.Отгонжаргал), нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар (Л.Эрдэнэчулуун), дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай</p>	<p>Дархлаажуулалтыг дүүргийн хэмжээнд зохион байгуулах</p>	<p>Дүүргийн Засаг даргын 2021 оны А/27 дугаар захирамжийн дагуу Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн вакцинжуулах ажлыг зохион байгуулж байна. ХӨСҮТ-ээс Астразеника үйлдвэрийн ковишил-538, Синофарм үйлдвэрийн Верецол-200 хүн тун вакцины татан авалт хийсэн. 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар /ИТХ, ЗДТГ, ЭМТ, ОБХ, ЦХ, МХТ, Хороод, Ахмадын хороо, Налайх Эрчим хүчний салбарын Өндөртолгой хэсэг, УСАТ, Илч-Орд ОНӨААТҮГ, Багахангайн тохижилт ОНӨААТҮГ-ын ажилтан, албан хаагчид болон 59-64 насны иргэдийн төлөөлөл/ нийт 616 иргэнийг вакцинд хамруулаад байна.</p>	<p>18-аас дээш насны дархлаажуулах ажил 23.1 хувьтай хийгдэж байна.</p>	<p>50</p>	
	<p>3.Байгууллагын үйл ажиллагааны хэвийн нөхцөл байдлыг алдагдуулахгүйгээр ажилтан,</p>	<p>Улбар шар түвшинд шилжсэнтэй</p>	<p>Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахалтай тэмцэх, халдварын эрсдлийг</p>	<p>Ажилтан, албан хаагчдын 70 хүртэлх хувь</p>	<p>90</p>	

		албан хаагчдыг 30 хүртэл хувиар ажиллуулж, бусад албан хаагчдыг ажил үүргээ зайнаас гүйцэтгэх нөхцөл боломжийг бүрдүүлэн, 0-12 насны хүүхэдтэй эх, өрх толгойлсон эцэг, эхийг гэрээр ажиллах боломжоор хангахыг төрийн байгууллага хуулийн этгээдийн удирдлагуудад зөвлөсүгэй.	холбогдуулан ажилтан, албан хаагчдыг 30 хүртэлх хувиар ажиллуулах цагийн хуваарь гаргах	бууруулах, хариу арга хэмжээ авах зорилгоор өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг улбар шар түвшинд шилжсэнтэй холбогдуулан 26 байгууллага 2021 оны 03 дугаар сарын 16-26-ны өдрийг дуустал ээлжээр ажиллах хувиар гарган албан хаагчдыг 30 хүртэлх хувиар гарган ажиллуулж байна. Багахангай дүүргийн Онцгой комисс, шуурхай штаб, ЭМТ, ОБХ, ЦХ нь шаардлагатай үед бүрэн бүрэлдэхүүнээр ажиллаж байна.	болон 0-12 насны хүүхэдтэй эх /эцэг/-чүүдыг гэрээр буюу цахимаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэн /техник хэрэгслийг гэрээр ажиллах боломжоор ханган/ үйл ажиллагааг тасралтгүй байдлыг ханган ажиллаж байна.		
		4.Нийслэлийн нутаг дэвсгэрт зохион байгуулан хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг иргэдэд мэдээлж, сурталчлахыг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтэс (Г.Хонгорзул), дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Нийслэлийн Засаг даргын А/161 дүгээр захирамжийг хэрэгжүүлэн ажиллах	НЗД-ын 2021 оны А/161 дүгээр захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор ДЗД-ын 2021.03.16-ны өдрийн “Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/36 дугаар захирамжийг батлан ААНБ-уудад хүргүүлж, “БАГАХАНГАЙ ДҮҮРЭГ-ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ” facebook хуудсаар дамжуулан иргэдэд хүргэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	Дүүргийн хэвлэл мэдээллийн нэгдсэн, цахим сайтад байршуулсан.		
14.	Хөрөнгө гаргах тухай 2021-02-10 А/88	3.“Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээний хүрээнд ажиллах дүүргийн төрийн байгууллагын албан хаагчдын хоол. унааны зардлыг дүүргийн төсвөөс санхүүжүүлж ажиллахыг дүүргийн Засаг дарга нарт даалгасугай	Шаардлагатай зардлыг шийдвэрлүүлэх	“Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 875.000 төгрөгийг дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж ажилтан, албан хаагчдын хоол, шатахуун, холбооны зардалд зарцуулсан	Тус арга хэмжээнд ажилласан албан хаагчдын шаардагдах зардлыг шийдвэрлэсэн		

Нийслэлийн Засаг даргын Албан даалгавар

15.	<p>Хог хаягдлын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зарим арга хэмжээний тухай 2021-02-08 01</p>	<p>1.1.Нийтийн эзэмшлийн зам талбай, орон сууц, гэр хорооллын гудамж, талбайд тээвэрлээгүй удсаны улмаас үүссэн ил задгай хог хаягдлыг бүрэн цэвэрлэж, хог хаягдлын ачилт тээвэрлэлтийн давтамжийг нэмэгдүүлэн, дахин үүсгүүлэхгүй байх арга хэмжээг авах, хог хаягдлын олон нийтийн байцаагчийг хороо тус бүрт томилж ажиллуулах</p>	<p>Аж ахуйн нэгж, байгууллага орчныхоо 50м хүртлэх цас мөс, хог хаягдлыг цэвэрлэх, орчны аюулгүй байдлыг хангуулах ажлыг зохион байгуулах.</p>	<p>Багахангай тохижилт ОНӨААТҮГ нь дүүргийн 1, 2 дугаар хорооны орон сууцны айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудын цас мөс цэвэрлэх, хог хаягдлыг авах зураглал болон цагийн хуваарийг мөрдөн ажиллаж нийтийн эзэмшлийн 133,118 м<sup>2</sup> гудамж, зам талбайн хог хаягдал, цас, мөсний цэвэрлэгээг хариуцан ажиллаж байна. ААНБ-ын хог хаягдлыг өдөр бүр 2 удаа, гэр хорооллын айл өрхийн хог хаягдлыг өвлийн улиралд 7 хоногт 1 удаа татан авч байна. Биелэлтийн хугацаанд 380 тн хог хаягдлыг татан авч дарж булшилж байна. Багахангай тохижилт ОНӨААТҮГ, хороо тус бүрт тохижилт, хог хаягдлын олон нийтийн байцаагч нарыг 2015 оноос томилон, хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж, 2021 онд 9 зөрчил илрүүлж зөрчлийн</p>	<p>Цагийн хуваарийн дагуу ААНБ-ын хог хаягдлыг өдөр бүр 2 удаа, гэр хорооллын айл өрхийн хог хаягдлыг өвлийн цагийн хуваарийн дагуу 7 хоногт 1 удаа, зуны хуваарийн дагуу 14 хоногт 1 удаа татан авч байна. Ачигч, жолооч нар 7 хоногт 3 удаа хогийн пункеруудад ариутгал хийж байна</p>	100	70
-----	--	---	--	--	--	-----	----

				тэмдэглэл хөтлөн шийдвэрлэн ажиллаж байна			
		1.2.Хог хаягдлын үйлчилгээ үзүүлдэг орон нутгийн болон хувийн өмчит байгууллагуудад хүчин чадлын үнэлгээ хийж, машин тоног төхөөрөмж дутуу, хуваарийн дагуу хогоо тогтмол ачдаггүй, хариуцсан бүс, хороо нь ил задгай хог хаягдал ихтэй байгууллагуудын хариуцсан хороодын тоог багасгаж, хүчин чадалд нь тааруулж ажиллуулах, хог хаягдал ачиж, цуглуулах үйлчилгээ хүрэхгүй байгаа бүс, хороодод сонгон шалгаруулалт зарлаж, машин техник, ажиллах хүчний нөөцтэй хог хаягдлын үйлчилгээний байгууллагыг ажиллуулах арга хэмжээг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан зохион байгуулах	Техник хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангах	Хог хаягдлын үйлчилгээ үзүүлдэг Багахангай тохижилт ОНӨААТҮГ-т хүчин чадлын УБЗАА болон дүүрэг хамтарсан үнэлгээ хийгдсэн. Кама ачааны машин УБА 91-47, Исузу ачааны УБЯ 45-49, УНП 16-11, ВОВСАТ олон үйлдэлт трактор, ковш 1 ширхэг, экскаватор 1 ширхэг, автовик УБУ 82-06 машин механизмыг автотээврийн үзлэг шалгалтад 1 удаа оруулав.	Хог ачилт, тээвэрлэлт хэвийн явагдаж байна.	100	
		1.4.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд төрөөс хариуцах болсонтой холбогдуулан хог тээврийн гэрээ хийгээгүй СӨХ, аж ахуйн нэгж байгууллагын судалгааг гаргаж, нутаг дэвсгэрийн нийт байгууллага: аж ахуйн нэгжийг бүрэн гэрээтэй болгох ажлыг 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор багтаан зохион байгуулах	Дүүргийн нийт аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах	Дүүргийн үйл ажиллагаа явуулж байгаа 32 ААНБ-тай хог хаягдал тээвэрлэлтийн гэрээ байгуулан хог хаягдлын хураамжийг дүүргийн татварын дансанд төвлөрүүлж байна. 20 ААНБ хог хаягдлын хураамжийг тогтмол төлж, 12 байгууллагын хог хаягдлын хураамжийг төрөөс бүрэн хариуцаж байна.	Хог хаягдал тээвэрлэлтийн гэрээг бүрэн хийж гүйцэтгэсэн.	100	



		<p>1.5. Аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг үүсгэж байгаа хог хаягдлын хэмжээнээс хамааруулан тооцож авах системийг 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдүүлэх, дүүргийн нэг иргэнээс авах хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг батлагдсан аргачлалын дагуу тооцож, 2021 оны 2 дугаар улиралд багтаан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулж, 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхлэх бэлтгэл ажлыг хангуулах</p>	<p>Албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс төвлөрүүлэх хогны хураамжийн тооцоо, аргачлалыг дүүргийн ИТХ-аар батлуулах</p>	<p>Үүсгэж байгаа хог хаягдлын хэмжээнээс хамааран хог хаягдлын хураамжийн хэмжээг аргачлалын дагуу боловсруулан дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэлийг хангасан.</p>	<p>Иргэн бүрт тооцох хог хаягдлын хураамжийн хэмжээг боловсруулав.</p>	<p>50</p>	<p>50</p>
		<p>1.6. Дүүргийн нутаг дэвсгэрийн айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгуулж хэвшүүлэх, ангилсан хог хаягдлыг долоо хоногийн тогтмол гаригуудад /хаягдал шил, лаазыг Лхагва гариг, хаягдал хуванцрыг Баасан гариг, хаягдал цаасыг Бямба гариг/ 7-14 хоногийн давтамжтай цуглуулж, тээвэрлэх бэлтгэл ажлыг хангуулж, 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн ангилсан хог хаягдлын тээвэрлэлтийг тогтмол хуваарийн дагуу эхлүүлэх</p>	<p>Нийтийн эзэмшлийн орон сууцны айл өрхийн ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж хэвшүүлэх</p>	<p>Дүүргийн нийтийн эзэмшлийн орон сууцны айл өрхийн хог хаягдлыг 1-р хороонд 3, 2-р хороонд 4 бункерээр, ААНБ-уудад 24 ширхэг цикль хогийн савыг байрлуулан тогтсон хуваарь, маршрутын дагуу хог хаягдлыг татан авч байна. Хогийн сав болон бункерт ариутгалыг 14 хоногт 1 удаа хийж хэвшсэн. Дүүргийн 1, 2 дугаар хороонд тус бүр 1 хог хаягдал ангилан ялгах зориулалт бүхий хогийн бункерыг шинээр хийж байршуулан 11 сандал, 23 хогийн сав</p>	<p>Багахангай ОНӨААТҮГ нь нийтийн эзэмшлийн орон сууц айл өрхийн хог хаягдлыг татан авч эх үүсвэр дээр нь хуванцар сав ангилан ялгалт хийж байна.</p>	<p>100</p>	<p>30</p>

			засварлав.			
	1.7. Албан даалгаврын хэрэгжилтийг сар бүрийн 25-ны дотор Улаанбаатар хотын Ерөнхий менежерт тайлагнаж ажиллах.	НЗД-ын 2021.02.08-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийн явцыг хамаарах заалт тус бүрээр танилцуулах	НЗД-ын 2021.02.08-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилт, явцын танилцуулгыг бэлтгэн 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн УБЗАА-ны удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд Засаг даргын орлогч Дэд бүтэц, байгаль экологийн төсөл хөтөлбөрийн удирдагчид танилцуулав.	Тогтоогдсон хугацаанд Нийслэлийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр албан даалгаврын биелэлтийг танилцуулав.	100	100
	3.1. Хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд ил задгай үүссэн хог хаягдлыг 14 хоногийн дотор бүрэн цэвэрлэж, тээвэрлэн, айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын хог хаягдлыг ачиж, тээвэрлэх давтамжийг нэмэгдүүлэн, шөнийн тээвэрлэлтийн хуваарийг нэвтрүүлэх,	Ил задгай хур хог үүсэхгүй байхад анхаарч ажиллах	Нийслэлийн Захирагчийн албатай гэрээ байгуулан дүүргийн 1, 2 дугаар хорооноос 4 иргэнийг 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 31 хүртэл авч ажиллуулахаар болов. 1. Хангай зөрлөгөөс Баян сумын зааг хүртэл 24 км газарт түүвэр цэвэрлэгээ хийж ажилласан. 2. Дүүргийн 1, 2 дугаар хороо холбосон авто замын дагуу түүвэр	Иргэдийн 2 бүлэг ажиллаж байна. Түр ажлын байраар 4 иргэн хамрагдаж УБЗАА-аас санхүүжиж байна.	100	

				<p>цэвэрлэгээг хийж ажилласан.</p> <p>3. Нийгмийн хариуцлагын хүрээнд 2 дугаар байрны ар талын хог хаягдал, цас мөсийг цэвэрлэн ажилласан.</p> <p>Нийт 16 үйлчлэгч өөрсдийн хариуцсан зам талбайг цэвэрлэн ажиллаж байна.</p>			
		<p>3.2.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 32/03 дугаар тогтоолоор батлагдсан “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах. булшлах журам”-д заасны дагуу байгууллагын өмчид бүртгэлтэй хог тээврийн зориулалттай автомашинуудын 1/3-ийг ангилсан хог хаягдал ачиж тээвэрлэхэд зориулан бэлтгэн, хуваарийн дагуу тогтмол тээвэрлэлт хийх,</p>	<p>ААНБ, орон сууц, гэр хорооллын болон нийтийн эзэмшлийн зам талбайд хогийн савыг байршуулан тогтсон хуваарь, маршрутын дагуу хог хаягдлыг татан авах</p>	<p>Дүүргийн 1, 2 дугаар хорооны орон сууцны айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудын цас мөс цэвэрлэх, хог хаягдлыг авах зураглал болон цагийн хуваарийг дүүргийн Засаг даргын орлогч, хороодын Засаг даргаар баталгаажуулан мөрдүүлэн ажиллаж байна.</p>	<p>Орчны бохирдол буурч, иргэд эрүүл, аюулгүй амьдрах орчин нөхцөл бүрдэнэ.</p>	100	90
16.	<p>Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 22 дугаар хуралдааны тэмдэглэлд: 2020-11-12 22-4</p>	<p>2.Дүүргийн Засаг даргын Тамгын газраас Сууц өмчлөгчдийн холбоонд тавих хяналтыг сайжруулах, хөрөнгө санхүүгийн хариуцлагагүй байдлыг зогсоох, Сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагаанд түвшин тогтоох үзлэгийг 2021 оны 1 дүгээр улиралд зохион байгуулж, үр дүнг Нийслэлийн Засаг даргын</p>	<p>Үлгэр жишээ СӨХ шалгаруулах болзолт уралдаанд оролцох</p>	<p>Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас нийслэлийн СӨХ-дын дунд зохион байгуулж буй болзолт уралдаанд оролцох ажлын хэсэг болон зохион байгуулах төлөвлөгөөг дүүргийн Засаг даргын 2021 оны</p>	<p>“Үлгэр жишээ хэрэгжүүлсэн сууц өмчлөгчдийн холбоо шалгаруулах” болзолт уралдаанд оролцох “Их хангай” СӨХ-ын хийсэн ажлын тайланг ЗДТГ-ын даргын 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 8/130 дугаар албан бичгээр УБЗАА-нд хүргүүлэв.</p>	100	

		Зөвлөлийн хуралд тайлагнаж ажиллахыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба /Т.Гантөмөр/-нд, Дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгов” гэжээ.		A/16 дугаар захирамжаар батлав. Уг арга хэмжээнд дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 1,495,000 төгрөг зарцуулав. Зохион байгуулсан ажлын явцын мэдээ, тайлан болон үнэлгээг УБЗАА-нд хүргүүлэв.			100
17.	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 01 дүгээр хуралдааны тэмдэглэлд: 2021-01-08 01-06а	Төрийн албан хэрэг хөтлөлтийн талаарх сургалтыг байгууллагадаа зохион байгуулж, албан хаагчдынхаа ур чадварыг дээшлүүлж ажиллахыг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлагуудад	Харьяа байгууллага болон албан хаагчдын дунд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг гарган батлуулах.	Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулсан сургалтын төлөвлөгөөг дүүргийн харьяа 26 байгууллагад 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдөр хүргүүлэн ажилласан.	Төлөвлөгөөний дагуу сургалт зохион байгуулагдана.	90	
18.	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 01 дүгээр хуралдааны тэмдэглэлд: 2021-01-08 01-06	1. Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг бүх талаас нь нягтлан судалж, хууль зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэж, хуулийн хугацаанд иргэнд хариу өгөх жишиг тогтоохыг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад	Холбогдох үүрэг чиглэлийг хэрэгжүүлэн ажиллах	Тайлангийн хугацаанд дүүргийн удирдлагуудад 31 иргэнээс өргөдөл ирсэн бөгөөд хуулийн хугацаанд шийдвэрлэн хариу өгөн ажиллалаа. Агуулгын хувьд орон сууц хүссэн болон ажилд орохыг хүссэн өргөдлүүд 70 хувийг эзэлж байна.	Хуулийн хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн өргөдөл байхгүй	90	
		2. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хийх дүн шинжилгээг сайжруулан, өргөдөл, гомдлын шалтгаан нөхцлийг байгууллагын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн нэгж, албан хаагч	Дүн шинжилгээ хийж, хэрэгжилтийг хангах	Тус хугацаанд ирсэн өргөдлийн хувьд иргэнээс бичгээр гаргасан өргөдлүүд байгаа бөгөөд шийдвэрлэлтийн	Зөрчил дутагдал гараагүй байна.	90	

	гэсэн байдлаар нарийвчлан судалж, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хугацаа, зөрчлийн үзүүлэлтийг бууруулах шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр тусгай төлөвлөгөө боловсруулан, биелэлтийг улирал тутам нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвд тайлагнах, мөн иргэдээс гаргасан саналыг байгууллагын үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлсэн байдлыг тайлан, мэдээнд тусгайлан оруулж, байгууллагын цахим хуудаст ил тод, нээлттэй байршуулж хэвшүүлэхийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад;		дундаж хугацаа 11 хоног 45 минут байна. Одоогийн байдлаар иргэд, албан хаагчаас ирсэн өргөдөл, гомдол, санал гараагүй байна. Үүрэг, чиглэлийг байгууллага, албан хаагчийн төлөвлөгөө тайланд тусган ажиллаж, тайлан, мэдээг тогтоосон хугацаанд дээд шатны байгууллагад хүргүүлж байна.			
	3. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын ERP системд ажиллах албан хаагчдын чадавхийг дээшлүүлэн, тус системд албан хаагчдыг бүртгэх, мэдээллийг шинэчлэх, засварлах арга хэмжээг тухай бүр шуурхай гүйцэтгэж, албан хаагчдад заавар, зөвлөгөөг тогтмол өгч ажиллахыг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын ERP системд албан хаагчдыг бүртгэх, мэдээллийг шинэчлэх, засварлах, албан хаагчдыг чадавхжуулна	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын ERP системд албан хаагчдын ажиллах чадавхыг дээшлүүлэх хүрээнд ажлын байранд нь дадлагажуулан заавар зөвлөмж өгч ажиллаж байгаа бөгөөд ажилд шинээр томилогдсон албан хаагчийг бүртгэх, ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчийг хасалт хийх, мэдээллийг тухай бүр шинэчлэх, засварлах ажлыг тогтмолжуулан ажиллаж байна.	Албан хаагчдын мэдээллийг тухай бүр шинэчлэн, системийн хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна.	100	
	4. Өргөдөл, гомдол хариуцсан албан хаагчдыг тогтвор	Төрийн үйл ажиллагааны	Тус газрын Гадаад харилцаа, өргөдөл,	Үйл ажиллагааны тасралтгүй байдлыг ханган ажиллаж	70	

		<p>суурьшилтай ажиллуулах, тухайн албан хаагч ажлаас чөлөөлөгдсөн болон удаан хугацаагаар өвчтэй, чөлөөтэй байх тохиолдолд ажлыг бүрэн хүлээлцүүлж, тасралтгүй, хэвийн үргэлжлэх нөхцөлийг хангаж ажиллахыг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад;</p>	<p>тасралтгүй хэвийн ажиллах нөхцлийг хангаж ажиллана</p>	<p>гомдол хариуцсан мэргэжилтний ажлын байр одоогоор сул байгаа бөгөөд сул орон тоог нөхөхөөр Төрийн албаны зөвлөлд тусгай шалгалтын захиалгыг хүргүүлээд байна. Өргөдөл гомдол хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагааны тасралтгүй, хэвийн үргэлжлэх нөхцөлийг хангах зорилгоор сул орон тоо нөхөгдөх хүртэлх хугацаанд ажлыг Эрх зүй, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгч хавсруулан гүйцэтгүүлж байна.</p>	<p>байна.</p>		
		<p>5. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг тухайн байгууллагын өргөдөл, гомдлын асуудал хариуцсан ажилтан өдөрт нь хүлээн авч, өргөдөл, гомдлын нэгдсэн системд бүртгэх, хянан шийдвэрлэх эрх бүхий этгээдэд өдөрт нь шилжүүлэх, өргөдөл, гомдолтой танилцсан албан хаагч уг асуудлыг өөрөө биечлэн хянаж шийдвэрлэхээргүй бол түүнийг хэрхэн судалж шийдвэрлэх талаар удирдлагын тэмдэглэл /цохолт/ бичиж харьяалах доод шатны байгууллага, албан хаагчид хянан шийдвэрлүүлэхээр өдөрт нь шилжүүлэх, удирдлагын цохолттой</p>	<p>Хэрэгжилтийг ханган ажиллах</p>	<p>Тус байгууллагад ирсэн өргөдөл, гомдлыг хариуцсан мэргэжилтэн өдөрт нь хүлээн авч, системд бүртгэж, холбогдох албан тушаалтанд шилжүүлэн шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байна. Өөрөө биечлэн шийдвэрлэсэн өргөдөл 5, шилжүүлсэн 26 өргөдөлд тэмдэглэл хөтлөн ажиллалаа. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 01 дүгээр</p>	<p>Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдаж байна.</p>	<p>90</p>	

		ирсэн өргөдөл, гомдлыг тухайн албан хаагч өдөрт нь хүлээн авч танилцах, явцын тэмдэглэлийг 10 хоног тутам хөтөлж, хэвшүүлэхийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад		хуралдааны тэмдэглэлийг дүүргийн төсвийн байгууллагуудад хүргүүлэн, тайланг улирал бүрийн сүүлийн сарын 10-ны дотор ирүүлэхийг үүрэг болгон ажиллаж байна.			
		6. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлээгүй, тайлан мэдээг дээд шатны байгууллагад тайлагнаж ажиллаагүй албан тушаалтанд хариуцлага тооцож, өргөдөл, гомдлын тайлан мэдээнд тусгах, бүх шатны байгууллага, албан тушаалтныг мэдээллээр хангах ажлыг тогтмол зохион байгуулж ажиллахыг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад;	Хэрэгжилтийг ханган ажиллах	Тайлангийн хугацаанд өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хугацаа хэтрүүлсэн зөрчил гараагүй байна.	Зөрчил дутагдал гараагүй байна.	100	
19.	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 02 дугаар хуралдааны тэмдэглэлд 2021-01-15 02-03	1. Албан хэрэг хөтлөлтийн “eDoc” системийн ашиглалтыг сайжруулах, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлагуудад;	Дүүргийн харьяа байгууллагуудын архив албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг сайжруулах, нэгдсэн удирдлагаар хангах.  Дүүргийн хэмжээний байгууллагын нийслэлийн удирдлагын нэгдсэн систем	Дүүргийн хэмжээнд 2063 албан бичиг ирж, 509 бичиг хариутай. Хугацаандаа шийдвэрлэсэн 449, хугацаа дөхсөн 6, хугацаа хэтрүүлсэн 11, судалж байгаа 130, шийдвэрлэлтийн хувь 99,51 байна. 2021 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар дүүргийн хэмжээнд 18 зөрчил тооцогдсон бөгөөд ихэнх зөрчил нь хугацаа хоцорч шилжүүлсэн зөрчил гарсан байна.	Албан хэрэг хөтлөлтийн программыг харьяа байгууллагууд бүрэн эзэмшиж, хариутай бичгийн шийдвэрлэлт сайжирсан.	90	

			<p>/erp.ulaanbaatar.m/-ийн албан хэрэг хөтлөлтийн дэд систем /edoc.ulaanbaatar.mn/-д бүртгэгдсэн нийт бичгийг шийдвэрлэх.</p>			
		<p>2. Албан бичгийн шийдвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хугацаанд нь хариу өгч ажиллахыг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад;</p>	<p>Албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн системд ажиллах, шийдвэрлэлтийг хянах, зохион байгуулах,</p>	<p>Дүүрэгт 1972 бичиг хянагдсанаас 14 албан бичгийг шийдвэрлэлтээс цуцлан, 1958 албан бичгийг хянан баталсан байна. ERP-Edoc программаар ирсэн бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавин холбогдох аж ахуйн нэгж, байгууллагуудад бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлэх талаар заавар зөвлөмжийг тогтмол өгч ажиллаж байна.</p>	<p>Хугацаа хэтэрч шийдвэрлэгдсэн бичиг багасаж, дүүргийн хэмжээнд 1958 албан бичиг хянагдсан байна.</p>	<p>90</p>